

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН:

СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



_____ /Г.ЭНХМӨНХ/

_____ Б.БАТТУУЛ

**ХОТГОРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙГААС НАРИЙНСУХАЙТЫН НҮҮРС
ТЭЭВРИЙН ЗАМ ХҮРТЭЛХ 288.45 КМ АВТО ЗАМЫН ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:2862468/

Хянасан:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны
Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн шинжээч
_____ 3.Азжаргал

Боловсруулсан:

СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК-ийн байгаль
орчны мэргэжилтэн _____ Ч.Дэлгэржаргал

2024 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ 10	
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	32
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
14. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	36

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төсөл хэрэгжүүлэгч: “Сэкер ресурс” ХХК, улсын бүртгэлийн дугаар:9019097451, регистрийн дугаар: 2862468

Төслийн байршил: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто зам

Сэкер Ресурсус Монголиа ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгор чулуун нүүрсний уурхайн бүтээгдэхүүнээ Шивээхүрэн боомтоор экспортлох зорилгоор Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэл нийт 288.45 км авто замыг барихаар төлөвлөж байна. Тус 288.45 км хатуу хучилттай авто зам нь дараах чигийн тэнхлэгийн координатын дагуу баригдана. Үүнд:

Эхлэх цэг: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2-р багийн нутагт дэвсгэрт орших Сэкер Ресурсус Монголиа ХХК -ийн Хотгор чулуун нүүрсний уурхайн (44° 34' 5.15" N; 99° 16' 36.51" E) талбайгаас эхэлнэ.

Төгсөх цэг: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам (42° 57' 21.07" N; 101° 16' 27.47" E) –тай холбогдоно.



Төслийн хүчин чадал: Замын трасс нь Монгол орны баруун урд хэсэгт автозамын цаг уурын IIВ, IIIА, IIIВ бүсэд хамаарах ба жилд 12 сая тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай баригдах бөгөөд өдрийн дундаж хөдөлгөөний эрчим 1,298-3,815 ш бага болон хүнд даацын авто машин өнгөрөхөөр төлөвлөсөн.

Ажиллах хүч: Төслийн хугацаанд буюу зам барилгын үед нийт 809 хүн ажиллана. Замын барилгын үндсэн үзүүлэлт: Автозам нь БНБД 32-01-07 “Автозам төсөвлөх стандарт”-ын дагуу III зэргийн замын шаардлагыг хангасан 2 талдаа 2 м өргөн хайрган хөвөө, ирмэгээрээ 0.5 м өргөн хучилттай зурвастай, 7 м-ийн өргөн зорчих хэсэгтэй, 2 эгнээ замыг барина.

Ус зайлуулах байгууламжийн асуудлыг шийдэж шаардлагатай газруудад хоолой, болон ус давуулах даланг төлөвлөсөн. Төслийн ТЭЗҮ-д тусгаснаар ус зайлуулах байгууламжийн хувьд 1х1 м хэмжээтэй дугуй хоолой – 439 ш, 1 : 1 :1 м хэмжээтэй дөрвөлжин хоолой – 30 ш, 2:1:1 м хэмжээтэй дөрвөлжин хоолой – 104 ш, 3:1:1 м хэмжээтэй дөрвөлжин хоолой – 26 ш, нийт дугуй болон дөрвөлжин хоолой 599 ш, 10,000 м урт ус давуулах далан 109 ш, нийт 708 ш ус зайлуулах байгууламж барихаар төлөвлөсөн байна. Эдгээр ус зайлуулах байгууламжууд нь 6 тэнхлэгтэй 100 хүртэл тн-ын даацтай хүнд даацын ачаатай машинуудыг даах чадвартай байхаар төлөвлөгдсөн. Уулархаг болон нугачаатай газар, ухмалтай хэсгүүдэд 199, 835 м трапец хэлбэрийн шуудуунуудтай байна.

Автозамын хучилтад асфальт бетон хучилт-50мм, цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь - -200 мм, цементээр бэхжүүлсэн байгалийн хөрсөн суурь-200мм, хөлдөлтөөс хамгаалах үе - 200 мм, ба далангийн үеүд нь 0.075 мм-ээс жижиг хэмжээтэй материалын агуулга нь 10%, дор хаяж 8%-ийн CBR-тэй байна.

Дэд бүтэц:

Цахилгаан хангамж – Зам барилгын ажлын үеийн цахилгааны хэрэглээг 50, 100, 200, 300, 350, 500kW-хүчин чадалтай нийт 74 дизель генератораар хангана.

Ус хангамж – Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байрлах өөрийн 8 худгаас болон Гурвантэс сумын нутагт байрлах 2 худгаас гэрээгээр зам барилгын ажилд шаардлагатай усыг хангана.

Түүхий эд – Авто замын барилгын ажилд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах сумдын засаг дарга нарын захирамжийн дагуу шороон материалын 5, элсний материалын 2, элс, шороо, чулууны 8 ордуудыг ашиглана.

Тоног төхөөрөмж – Гинжит трактор, дугуйт трактор, бульдозер, грейдер, дугуйт ачигч, экскаватор, хүнд даацын ачааны машин зэргийг авто замын барилгын ажилд ашиглана.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүй. Говь-Алтайн уулт тогтолцооны гарал үүслийн хөгжил нь шинэхэн тектоникийн уул үүсэх хөдөлгөөнтэй холбоотой бөгөөд энэ асуудлаар судлаачдын санал нэлээд хол зөрүүтэй бас маргаантай байдаг боловч ихэнх нь Говь-Алтайн уулт өргөгдлийг плиоцен, плейстоцены заагт болж өнгөрсөн гэдэг ба тогтцын хувьд хагарлуудаар хэсэг бүлэг блокуудад хуваагдаж шилжин хөдлөхийн зэрэгцээгээр янз бүрийн цаг үеүдэд эргэж хөрвөж, атирч, эвдэрч өөрчлөгдсөн нэн эдрээтэй, нийлмэл бүтэцтэй гэж үздэг. Говь-Алтайн нуруу, түүний системд багтаж буй өмнөд хэсгийн зэрэгцсэн, цуварсан хэсэг бүлэг уулс, тэдгээрийг өөр хооронд нь заагласан өргөн уудам бэл хөндийг шинээр тавигдах автозам дамжин өнгөрөхөөр төлөвлөгджээ.

Цаг уур, уур амьсгал. Төслийн талбай орчмын газар нутаг нь эх газрын эрс тэс, хахир ширүүн, хуурай-дулаан-хүйтэвтэр хосолсон уур амьсгалтай бөгөөд өвөл нь хүйтэвтэр, зун нь аагим халуун, хавар намар нь салхитай дулаан байдаг. Гурвантэс сумын нутагт агаарын жилийн дундаж температур 4.0°C-4.6°C, агаарын үнэмлэхүй температур жилийн бүх сард эерэг (тухайлбал, өвлийн 1-р сард +7.8°C) байдаг. Түүнчлэн Гурвантэс суманд салхины жилийн дундаж хурд 3.6м/с, намар болон хавар 4-6м/с, өвлийн саруудад 3-4.7м/с, бусад саруудад 2-4м/с байна. Тус нутаг нь салхины хагалбар урсгалын дагуу баруун хойдоос зүүн өмнө рүү салхилах үндсэн горимтой бөгөөд ихэвчлэн “уул хөндийн” салхи зонхилно.

Агаарын чанар. Замын трасс нь нэлээд өргөн нутаг дэвсгэрийг хамарч байгаа тул трассын дагуу нийт 12 цэгийг сонгон агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэсэн байна. Шинжилгээний дүнгээр агаар дахь хүхэрлэг хийн агууламж 0.005-0.010 мг/м³, азотын давхар ислийн агууламж 0.009-0.024 хii Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто замын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (Нэмэлт тодотгол) - 2024 он мг/м³, нийт тоосны агууламж 0.016-0.024 мг/м³ байсан ба Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2016-д заасан нэг удаагийн зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас бага түвшинд байна. Хээрийн судалгааны хугацаанд хүчтэй шороон шуурга зэрэг байгалийн онц үзэгдэл ажиглагдаагүй ба замын трассын дагуу агаар дахь нийт тоосны агууламж ерөнхийдөө жигд бага байна. Хүхэрлэг хий, азотын давхар ислийн хувьд ерөнхийдөө мөн жигд бага илэрцтэй байгаа нь төслийн талбайн хэмжээнд эдгээр бохирдуулах бодисуудыг ялгаруулах бусад эх үүсвэр одоогоор байхгүй байгааг харуулж байна. Төслийн талбайн ихэнх нутаг дэвсгэр чимээ аниргүй бөгөөд энэ бүс нутаг дахь цөөн тооны малчид, зэрлэг болон ахуйн мал амьтдаас өөр дуу чимээ

үүсгэх эх үүсвэр байхгүй. Хэмжилтийн үр дүнгээс харахад дуу чимээний түвшин нь хэвийн бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээний хязгаарт байна. Өдрийн цагаар шувууд, шавжийн идэвхжилттэй холбоотойгоор дуу чимээний түвшин нэмэгддэг. Судалгааны үеэр дуу шуугианы хамгийн их түвшин 38 дБ(А)-с хэтрээгүй байна.

Хөрсөн бүрхэвч. Судалгаанд замын трассаас хоёр тийш 1.5 км буюу нийтдээ 3 км өргөн зурвасыг хамруулсан бөгөөд талбайн хүрээнд аараг толгод бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл ихтэй нам уулс болон тэдгээрийн хоорондох өргөн нарийн хуурай сайрууд, тэгшивтэр хөндий болон талархаг гадарга, жижиг дов довцог, шалархуу хотгор хонхор, элсэрхэг дов довцог зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 886-2315 м өндөрт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Борсаарал, Бор, Цайвархүрэн, Сайрын хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн, сайргархаг, элсэн, хужирлаг төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин багаас маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-30 см), хэврэг өрмөцөр, жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэргүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж маш сул байдаг онцлогтой. Мөн маш их чулуурхаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн ВВС-С гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж 0.1-1.6%, бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 7.78-9.0 буюу дунд зэрэг шүлтлэгээс маш хүчтэй шүлтлэг, хялбар уусах давсжилт хужирлаг болон гөлтгөнө, хурдас бүхий хөрсний бүх үе давхаргад их (2.1-2.2 dS/m) агууламжтай, бусад хөрсөнд багаас дунд зэрэг буюу 0.1-0.52 dS/m байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр бүрэлдэхүүнтэй. Нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна.

Гадаргын ус. Төлөвлөж буй автозамын трасс дагуу түүний ойр орчмын нутаг нь манай орны түр урсгал бүхий гол горхитой мужид хамаарна. Эндхийн газар нутаг хуурайдуу, салхи ихтэй ба усны ууршилт их явагдана. Тус бүс нутагт жилд усны гадаргаас уурших усны хэмжээ 1000 мм ба түүнээс их байна. Энэ нь жилд орох хур тунадаснаас 10 ба түүнээс олон дахин их гэсэн үг юм. Тус бүс нутгийн сайрууд цас их унасан жилд хавар шар усны үертэй, харин зун хур бороо болон эрчим ихтэй аадар борооны усаар тэжээгдэн түр урсгалтай болох ба үерлэнэ. Жилийн бусад хугацаанд сайр, гуу жалга, судаг урсацгүй. Хур бороо ихтэй услаг жилд, ялангуяа эрчимжилт ихтэй түр зуурын хур борооны улмаас сайр, судаг, гуу жалга үерлэдэг. Энэ

орчмын нутгийн гадаргуугийн хэрчигдэл их, сайрын сав газрын гидрологийн нөхцөл хүнд зэрэг байдал нь барилгын ажил гүйцэтгэхэд ихээхэн хүн хүч, зардал хөрөнгө, машин техник шаардах зэрэг бэрхшээл учруулахаар нөхцөлтэй. Замын нийт уртын дагуу түүнд хөндлөн эсвэл янз бүрийн өнцөг үүсгэсэн чиглэлд огтолсон сайр, судгуудын гулдирлын хэвгий нь харилдан адилгүй, эхээс адаг хүртэлх дундаж хэвгий нэлээд их буюу 10-45 промилль байна. Иймээс сайруудад ширүүн урсгал ажиглагдана. Тачир сийрэг ургамалтай, сул, нуралтад өртөмхий, ихэнхдээ шавар агууламжтай хайрга чулуурхаг ба элс бүхий хөрстэй. Энэ газарт хур тунадасны урсцаар хөрс, чулуулгийн жижиг ширхгүүд зөөгдөж урсах, уул, толгодын хажуу бэл хормойн хур тунадаснаас үүсэх нэл урсац цугларах хэсэгт хөрсний эвдрэл хүчтэй үүсэж болно. Говь цөлийн бүс хэдийгээр хур тунадас багатай, хуурай нутаг боловч хур тунадас, ялангуяа эрчим их, тур зуурын хүчтэй аадраар сайр, судгууд үерлэх нь өндөр магадлалтай хiii Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто замын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (Нэмэлт тодотгол) - 2024 он байдаг. Гэхдээ үер ховор тохиолдох ба богино хугацаанд ажиглагдах хэдий ч зам, ус зайлуулах байгууламжийг эвдлэх, машин техникийг урсах зэрэг тохиолдол гарах магадлалтай.

Газрын доорх ус. Гидрогеологийн региональ зүй тогтлын хувьд тус бүс нутаг нь Өмнөд говийн бүсэд хамаарна. Тухайн бүс нутгийн физик газарзүй, геологийн тогтоц, тектоник зэрэг нөхцөлүүдийг харгалзан Хотгор-Шивээ хүрэн чиглэлийн замын трасс дагуу гидрогеологийн хэд хэдэн үндсэн структур ялгаж, структур тус бүрээр нь тухайн орчны гидрогеологийн нөхцөлийг тодорхойлсон байна. Өндөр өргөгдсөн уулсыг гидрогеологийн массив, уулс хоорондын хотгорыг гидрогеологийн бассейн гэж ялгадаг. Энэхүү замын трассын чиглэлд геологийн тогтоц буюу газрын доорх ус агуулах геологийн орчны хувьд хоорондоо ялгаатай хэд хэдэн гидрогеологийн массив болон бассейн ялгагдана. Газрын доорх ус агуулах геологийн орчин буюу гидрогеологийн структур нь бүс нутгийн геологийн хөгжлийн түүх, тектоник хөдөлгөөний өрнөл, эдгээрийн дараа хэлбэржин тогтсон орчин үеийн геологийн биетүүдийн хэлбэр зэргээс хамааран өөр өөрийн онцлогтой. Говь-Алтайн нуруу, түүний системд багтаж буй өмнөд хэсгийн бүс геологийн судалгааны үр дүнгүүдээс үзэхэд энэ бүс нутгийн геологийн үндсэн суурь нь палеозойн настай чулуулгууд байх бөгөөд эдгээр нь палеозойн эринээс хойш олон удаагийн тектоник хөдөлгөөн, геологийн үйл явцын үр дүнд хэд хэдэн блок структурт хуваагдаж одоогийн уулсын үндсэн хэлбэр төрх бий болж, улмаар зэрэгцсэн, цуварсан хэсэг бүлэг уулс, тэдгээрийг өөр хооронд нь заагласан өргөн уудам бэл хөндийнүүд үүссэн байна. Улмаар мезо-кайнозойн эринд уулс хоорондын хөндийнүүдэд хурдас хуримтлал явагдан

дүүргэгдэж, газрын доорх ус их хэмжээгээр агуулах боломжтой бассейнүүд буюу газрын доорх усны ай савууд үүссэн аж. Мезо-кайнозойн эриний төгсгөлийн шатанд бүс нутгийн хэмжээнд мөн тектоник хөдөлгөөн идэвхжиж өмнө үүсэн бий болсон гидрогеологийн үндсэн структурүүдийн хэлбэр зүйг өөрчлөн одоогийн хэлбэр төрхийг бий болгосон байна.

Ургамлан нөмрөг. Төлөвлөж буй авто замын трассын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Алашаа говийн (цөлийн) тойргоос Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойрог, Алтайн өвөр говийн (цөлийн) тойргуудад хамаарагддаг. Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө бүхэлдээ 4 хэв шинжид хамаарах 8 хэвшил, 15 бүлгэмдэл тархсан байна. Уг судалгаагаар төслийн талбайн болон түүний ойр орчмын цөл, цөлийн хээрийн ургамлан бүлгэмдлийг дагаж 22 овогт хамаарах 54 төрлийн 65 зүйл ургамал бүртгэгдсэн. “Монгол орны улаан ном” (2013)-ын ургамлын жагсаалтад орсон нэн ховор ургамал төслийн талбай орчимд тохиолдохгүй. “Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл” (2012) -д бүртгэгдсэн хамгааллын статустай ургамал *Amygdalus mongolicus* - Монгол бүйлс устаж болзошгүй, *Cariophyteris mongolica*- Монгол Догар, *Peganum harmala* - Эгэл өмхий өвс эмзэг, *Arnebia gutata* - толбот бэрмэг анхааралд өртөхөөргүй ангиллаар орсон. БОАЖЯ-ны сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/603 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт ургамлын жагсаалт”-д орсон ховор статустай 4 зүйл, элбэг статустай 34 зүйл тохиолдоно.

Амьтны аймаг. Судалгааны талбай нь Монгол улсын хөхтөн амьтны улаан дансны Бүс нутгийн тархалтын бүсчлэлээр Говь Алтай нуруу, Алтайн өвөр говь цөл, Алашаа говь цөлийн бүсэд хамаарна. Трассын дагуу талбайд 5 зүйл могой, 7 зүйл гүрвэл нийт 12 зүйл мөлхөгч амьтан тэмдэглэгджээ. Энд монгол орны хамгийн том гүрвэл болох Замба гүрвэл (*Laudakia stoliczanal*), цоохор хонин гүрвэл (*Phynoccephalus versicolor*), төмөр гүрвэл (*Alsophylax ripiens*), нохой гүрвэл (*Teratoscincus przewalskii*), могой гүрвэл (*Eramias multiocellata*), говийн гүрвэл (*Eramias przewalskii*), загалт гүрвэл (*Eramias meremiculata*), нарийн могой (*Coluber spinalis*), тэмээн сүүл могой (*Eryx tataricus*), сум могой (*Psammophis lineolatus*), рашааны могой (*Elaphe diene*), бамбай хоншоорт могой (*Gloydus halys*) бий. Трассын дагуух талбай орчимд жигүүртэн шувуудын 40 орчим зүйлийг илрүүлэв. Эдгээр зүйлүүдээс монгол улсын улаан номд бүртгэгдсэн шувуудаас хулан жороо цөөн таарав. Трассын дагуу тохиолдох голлох жигүүртний зүйлүүдийг амьдралын хэв маягаар нь ялгавал уулын бэл, аараг толгод, хадархаг хавцал, гуу жалга, асга чулуу, сухайн довцгоор хахилаг хив Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто

замын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (Нэмэлт тодотгол) - 2024 он ятуу, үетэн- таана, баглуурт хайрган хөрст дагжуур говь цөлөрхөг хээрт ногтруу, элсэн манхан сул элс, хармаг, сухай, бут сөөгт элсэн довцогт хулан жороо, хотны бүгээхэй, өндөр уулын хад цохио, хясаа, таг нугаар тас, ёл тохиолдоно.

Нийгэм, эдийн засаг. Баянхонгор аймаг нь 89,643 хүн амтай бөгөөд үүнээс 45,453 (50.7%) эмэгтэй, 44,190 (49.3%) эрэгтэй байна. Нийт хүн амын 32,665 нь аймгийн төвд, 10,017 нь сумуудын төвд, 46,961 хүн хөдөө амьдарч байна. Аймгийн хэмжээнд 26,737 өрхтэй бөгөөд үүний 72.7% буюу 19,432 өрх нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, 27.3% буюу 7,305 өрх нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна. Нийт өрхийн 9,746 өрх нь аймгийн төвд, 3,057 өрх нь сумуудын төвд, 13,934 өрх нь хөдөө оршин сууж байна. Аймгийн нийт хүн амын 2.85% буюу 2,562 нь Шинэжинст суманд амьдарч байгаа бөгөөд үүний 49.25% буюу 1,262 хүн нь эрэгтэй, үлдсэн 50.75% буюу 1,300 хүн нь эмэгтэй байна. Сумын хэмжээнд 823 өрх оршин сууж байна. Өмнөговь аймаг нь 75,458 хүн амтай бөгөөд үүнээс 37,738 (50.01%) эрэгтэй, 37,720 (49.99%) эмэгтэй байна. Насны бүтцээр ангилбал 33.2 хувийг 0-14 насны хүүхэд, 59.5 хувийг 15-59 насны, 7.4 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна. 2023 оны эцсийн байдлаар өрхийн тоо 25,338 болж өмнөх оноос 1,623 өрхөөр буюу 6.8 хувиар өссөн дүнтэй байна. Аймгийн нийт хүн амын 7% буюу 5,283 нь Гурвантэс суманд амьдарч байгаа бөгөөд үүний 50.5% буюу 2,668 хүн нь эрэгтэй, үлдсэн 49.5% буюу 2,615 хүн нь эмэгтэй байна. Сумын хэмжээнд 1,765 өрх оршин сууж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын чулуун нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45км авто зам төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ЗГ-ын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын дагуу байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч тусгасан.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлсэн.

Төслийн **болзошгүй нөлөөллийн үнэлгээг** магадлан жагсаах болон матрицын аргаар үнэлсэн. Үүнээс **гол сөрөг нөлөөллийг** ялган авч төслийн бүтээн байгуулалтын болон ашиглалтын үеийн нөлөөллийг Оноот үнэлгээний аргаар тус тус үнэлсэн.

№	Нөлөөлөл	Нөлөөллийн түвшин	Нөлөөллийн үнэлгээ
А	Фикик нөлөөлөл	-11	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
А1	Агаарын чанарын нөлөөлөл	-9.25	Дунд зэргийн сөрөг
А2	Газрын гадарга, хэвлий	-15.3	Их сөрөг
А3	Хөрсөн бүрхэвч	-13	Дунд зэргийн сөрөг
А4	Ус	-6.5	Дунд зэргийн сөрөг
В	Биологийн олон янз байдал	-12	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
В1	Ургамлан нөмрөг	-11.5	Дунд зэргийн сөрөг
В2	Амьтны аймаг	-12.5	Дунд зэргийн сөрөг
С	Нийгэм-Эдийн засгийн нөлөөлөл	+7.33	Бага зэргийн эерэг нөлөөтэй
С1	Ажил эрхлэлт, дэд бүтэц, эдийн засаг	+7.33	Бага зэргийн эерэг
	Нийт нөлөөлөл	-8.67	Бага зэргийн сөрөг нөлөөтэй буюу зөвшөөрөх боломжтой

Төслийг хэрэгжих явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн түвшинг тогтоох зорилгоор эерэг болон сөрөг нөлөөллүүдийг жагсааж нөлөөллийн үргэлжлэх хугацаа, үйлчлэх хүрээг шинжилж хувийн жинг тодорхойлох замаар шинжилгээ хийв. Нийт нөлөөллийн 67.5% нь шууд, 20% нь шууд бус буюу болзошгүй сөрөг нөлөөлөлд хамаарна.

Нөлөөллийн 65% нь дунд хугацааны нөлөөлөлд 22.5% нь урт хугацааны, 12.5% нь богино хугацааны сөрөг нөлөөлөлд хамаарна. Нөлөөллийн шинжилгээнээс үзэхэд нийт нөлөөллийн 24% нь эерэг, 32% нь бага зэргийн хүчтэй, 30% нь дунд зэргийн хүчтэй, 14% нь их хүчтэй нөлөөлөлд тус тус хамаарч байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгорын нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45км авто зам байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд авто зам байгуулах үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр БОННУ-ний тайлангаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгож ажиллана. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн 5 жилийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн бууруулах										
1	Замын ажилд шаардлагатай материалыг карьераас олборлоход агаарт тоосжилт үүсэх	Карьераас материал олборлолтын үед болон газар шорооны ажлын үед усалгаа хийх	Карьерууд	Усалгаа	-	-		Барилгын ажил явагдах саруудад сард 10 удаа усалгаа хийх	Ерөнхий гүйцэтгэгч	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS4585:2016. MNS 5885-2008
2	Зам барилгын ажлын үед түр замаас агаарт тоосжилт үүсэх	Зам барилгын үед түр замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх.	Түр зам	км	-	-	ҮАЗ	Барилгын ажил явагдах үед	Ерөнхий гүйцэтгэгч	

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

3		Засаж сайжруулсан түр замаас гаргахгүйн тулд MNS4597 2014 Автозамын тэмдэг, техникийн ерөнхий шаардлагын дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Түр зам	ш	0.1	40.0	ХАБЭА-н зардлаас	Жил бүрийн замын төлөвлөлтөөс хамаарна	Ерөнхий гүйцэтгэгч	MNS4597:2014.
4		Түр замын дагуу тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт хийх, хурдны хязгаар тогтоосон дотоод журам боловсруулан хэрэгжүүлэх	Түр зам	-	-	-	-	Эхний жилд журам боловсруулж дагаж мөрдөх	Ерөнхий гүйцэтгэгч	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS4585:2016. MNS 5885-2008
5		Түр шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж	Түр зам	км	ҮАЗ	-	ҮАЗ	ҮАЗ	Ерөнхий гүйцэтгэгч	

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

		сайжруулах, нягтаршуулах								
		Зардал					-			
2.Хөрсөн бүрхэвч газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах										
6		Зам байгуулах, карьераас олборлолт хийх, ажилчдын кемп байгуулах зэрэг талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	Төслийн талбай	га	-	-	ҮАЗ	Үйл ажиллагаан ы турш	Ерөнхий гүйцэтгэгч	
7	Төслийн үйл ажиллагаагаа р нийт 4,320.0 мян.м3 шимт хөрс хуулна.	Шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хуулж, хадгалах. Хөрсний овоолгуудын дээд болон хажуу гадаргууг хэлбэржүүлж, шимт хөрсийг салхинд хийсэх, усанд урсах, бохирдох зэргээс хамгаалах	Шимт хөрсний овоолгууд	м3	-	-	ҮАЗ	Үйл ажиллагаан ы турш	Ерөнхий гүйцэтгэгч	MNS5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
8		Шимт хөрсний ойр орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Шимт хөрсний овоолгууд	ш	0.1	40.0	ҮАЗ	Үйл ажиллагаан ы турш	Ерөнхий гүйцэтгэгч	

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

9	Хүнд машин механизм, машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдэл болох хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Машин техник, тоног төхөөрөмжөөс шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний дотоод журмыг боловсруулах	Төслийн талбай	Баг	-	-	-	Эхний жил дотоод журмыг боловсруулал, цаашид дагаж мөрдөх	Ерөнхий гүйцэтгэгч	MNS5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
10		Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг авто замын барилгын бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	Зогсоолууд, Ажилчдын түр кемп	Багц	0.5	8.0	ХАБЭА-н зардлаас	Эхний жил	Ерөнхий гүйцэтгэгч	
		Зардал					-			
3.Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах										

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

12	Ус ашиглах гэрээ, дүгнэлтэд заасан ашиглах хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх тухай үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах талаар төслийн болон гэрээт нийт ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах.	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS6148:2010. Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
13	Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах бөгөөд шугам хоолой бүрийн тоолуурын баталгаажуулалт, түүний хяналтыг хийх	Төслийн талбайн уст цэгүүд	ш	1.0	10.0	10.0	Эхний жил	Ерөнхий гүйцэтгэгч		
	Зардал					10.0				
4.Ургамлан нөмрөг										

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

14	Төслийн үйл ажиллагаагаар эвдрэлд өртөх, шимт хөрсийг хуулснаар ургамлын нөмрөг устгах	Авто замын ажлын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх (тэмдэг тэмдэглээ байршуулах).	Төслийн талбай	ш	0.1	20.0	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
15	Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарсны улмаас ургамлын бүрхэвч бохирдож болзошгүй.	Замын ажилчдад төсөлд тусгасан замаас бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх	Төслийн ажилчид	Удаа	-	1.0	-	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	Байгалийн ургамлын тухай хууль ургамлын тухай хууль
		МУ-ын улаан ном, Бүс нутгийн болон олон улсын улаан дансанд бүртгэлтэй, олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан ховор, нэн ховор ургамлын талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээт ажилчдад мэдээлж, хамгаалалтын	Төслийн ажилчид	Удаа	-	1.0	-	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	Байгалийн ургамлын тухай хууль ургамлын тухай хууль

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

		талаар мэдээлэл хүргэх								
		Зардал						-		
5.Амьтны аймаг										
16		Хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт ухуулга явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх.	Төслийн ажилчид	Удаа	2.0	1	ҮАЗ	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
17	288.45км автозам нь зэрлэг амьтдын амьдрах орчныг торойгуулах, хуваагдал үүсэх	Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ойр орчмын ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбай орчим	Удаа	10.0	1	10.0	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
		Зардал						10.0		
6.Физик нөлөөлөл										

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

18	Ахуйн болон шингэн хаягдлаас үнэр ялгарч, ажилчид болон ойр орчинд таагүй нөлөөлнө.	Хог хаягдлын түр цуглуулах талбай болон хог хаягдлын цэгийн ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийх, элдэв үнэр, халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх.	Төслийн талбай болон түүний ойр орчим	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав.			Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	
19	Авто замын барилгын ажлын үйл ажиллагаанд ашиглагдах машин, техникийн хөдөлгөөн, үйл ажиллагаанаас дуу чимээ үүсэж амьтад үргэж дайжна.	Зайлшгүй шаардлагатай биш бол тээврийн хэрэгслийн дуут тохиог хэрэглэхгүй байх. Тээврийн хэрэгслийг сул зогсох үед заавал унтрааж байх	Төслийн ажилчид	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	MNS 6768:2019. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
7.Тусгай хамгаалалттай газар нутаг										

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

20	Төслийн үйл ажиллагааны газар шорооны ажлын дуу чимээ, машин техникийн хөдөлгөөний нөлөөгөөр амьтад үргэж дайжих	Замын ажилчдад төсөлд тусгасан замаас бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх	Ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний				Ерөнхий гүйцэтгэгч	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
21	Үйл ажиллагааны үед дуу чимээ, машин техникийн хөдөлгөөний нөлөөгөөр амьтад үргэж дайжих, стандарт гарц гарам төлөвлөөгүй тохиолдолд зэрлэг амьтанд дайрагдаж, үрэгдэх	Авто зам дээр мал, амьтан ихтэй хэсэгт өнгөрөх гарц гаргах, саадгүй нэвтрэх боломжийг бий болгох, тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаар хэмжээг зааж өгөх, тэмдэг тэмдэглэгээ тодорхой цэгүүдэд байрлуулах	Төслийн талбай болон түүний ойр орчимд	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний			Ерөнхий гүйцэтгэгч	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
		Нийт зардал					20.0	

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын чулуун нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45км авто зам төслийн зам барилгын ажил 2 жил үргэлжилж нийт 724.26 га талбай эвдрэлд өртөхөөр тооцоолсон.

Тус төслийн автозамын барилгын ажлын эхний жилд тул техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй бөгөөд нэмэлтээр карьер нээх үед холбогдох төрийн байгууллагаас зөвшөөрөл авч, ашиглаж дуусмагц түр замууд болон кемпийн газрын хамт MNS 5917 2008 стандартын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, зам барилгын ажлын сүүлийн жилд харьяа нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Орчны тохижилт, нөхөн сэргээлт									
1	Тэрбум хөдөлгөөний хүрээнд мод тарих	ӨМА-н Тэрбум мод хөдөлгөөний төлөвлөлтийн дагуу нөхөн сэргээлтийн 50га талбайд навчит мод тарих зардлыг шийдвэрлэх- Ханхонгор сум	нөхөн сэргээлт	ш	500	11,250	5,625,000	Намар	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
	Нийт						ҮАЗ		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн археологийн авран хамгаалах малтлага судалгааг 2012 онд Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаагаар нийт 5 дурсгалыг малтан судалж, нөхөн сэргээж, тэмдэглэн баримтжуулалт хийсэн байна. Харин төслийн талбайн палеонтологийн нөөц баялгийн үнэлгээг 2023 онд Шинжлэх ухааны академийн палеонтологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үед эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна. Замын болон карьер олборлолтын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн дурсгал, олдвор санамсаргүй байдлаар олдсон

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т заасны дагуу ажлаа зогсоож, энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэж, арга хэмжээ авна.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, сая/төг	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжүүлэгч	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нүүлгэн шилжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах	Төлөвлөлтийн үе шат	Шууд нөлөөлөлд өртөх болон шууд бус нөлөөлөлд өртөх айл өрхүүдийг нарийвчлан тодорхойлох- Төсөл хэрэгжиж буй сумдын засаг даргын тамгын газраас трассын дагуу нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхүүдийн албан ёсны мэдээлэл авах	2	2.00	2.00	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө болон эхний жил	Захиалагч	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/618 тоот тушаал

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

2		Төслийн нөлөөллийн бүсэд буй айл өрхүүдийн нийгэм, эдийн засгийн мэдээллийг нарийвчлан гаргах. Хөрөнгөний үнэлгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, үнэлгээ хийлгэх	1	2.00	2.00	Үйл ажиллагааны эхний жил	Захиалагч
3		Нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөх	1	2.00	2.00	Үйл ажиллагааны эхний жил	Захиалагч
4		Нүүлгэн шилжүүлэх болон тохиролцох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, нөлөөллийн бүсийн иргэдтэй гурвалсан гэрээ хийх	1	2.00	2.00	Үйл ажиллагааны эхний жил	Захиалагч
	Нийт				8.00		

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая/төг	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжүүлэгч	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Байгалийн гамшигт үзэгдэл	Төслийн онцгой байдал, осол эрсдэлийн үед “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан, жил бүр сайжруулж мөрдөн ажиллах	Ерөнхий гүйцэтгэгч	1	–	–	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 3 жилд 1 удаа хийлгэх ба үйл ажиллагааны турш даган мөрдөнө.	Ерөнхий гүйцэтгэгч	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Гамшгаас хамгаалах тухай хууль
2		Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагажуулах	Ерөнхий гүйцэтгэгч	1	2.00	ХАБЭА-н зардлаас	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	
3		ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ,	Ерөнхий гүйцэтгэгч	-	–	–	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

		дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх							
4	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж төслийн талбайд байршуулах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Төслийн талбай	2	1.10	ХАБЭА-н зардлаас	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS5566:2020. Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244:1994. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS0639:2016. Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо ба тодорхойлолт
5		Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект бүрд онцлогийг тусган тавих	Төслийн талбай	Самбар-4ширхэг	0.15	ХАБЭА-н зардлаас	Бүтээн байгуулалтын үед	Ерөнхий гүйцэтгэгч	
6	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн ажилчид	Иж бүрдэл	ҮАЗ	ХАБЭА-н зардлаас	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	MNS6654:2017. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт,

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

									хэрэглээнд тавих ерөнхий шаардлага MNS ISO13688:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага
7		Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Төслийн ажилчид	Нэгж сургалт	–	–	Үйл ажиллагааны тушт	Ерөнхий гүйцэтгэгч	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
8	Автомашинны осол авар	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдүүлж ажиллах	Ажилчид	Нэгж сургалт	–	–	Үйл ажиллагааны тушт	Ерөнхий гүйцэтгэгч	Замын хөдөлгөөний дүрэм, Замын аюулгүй байдлын тухай хууль
9	Химийн бодис	Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу хадгалах, тээвэрлэх, ашиглах	Ерөнхий гүйцэтгэгч		–	–	Үйл ажиллагааны тушт	Ерөнхий гүйцэтгэгч	Монгол Улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам MNS4992:2000
10		Химийн бодис хадгалах, ашиглах үед химийн бодис асгарсан, алдагдсан, гал түймэр гарснаас үүсэж болзошгүй аюул, ослын үед ажиллах дүрэм журмыг боловсруулан, жил бүр ажилчдад таниулан, дагаж мөрдөх	Ерөнхий гүйцэтгэгч	Сургалт нэгж	–	–	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

11		Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, саармагжуулах асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах (элс, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, хүрз, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болог тууз зэрэг)	Төслийн талбай	Иж бүрдэл	1.00	ХАБЭА-н зардлаас	Үйл ажиллагааны турш	Ерөнхий гүйцэтгэгч	
	Нийт					ХАБЭА-н зардлаас			

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Энгийн хог хаягдал	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг талбайд байршуулах	Төслийн талбай	Ширхэг	0.75	3.00	ҮАЗ	Эхний үед	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл (Шинэчилсэн найруулга), Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
2		Ахуйн хатуу хог хаягдлын ангилан ялгах цэг байгуулах	Төслийн талбай	Ширхэг	1.00	1.00	ҮАЗ	Эхний үед	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 4-р бүлэг БОАЖ-ын

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

3	Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг аймгийн хог хаягдал дахин боловсруулах төсөл хөтөлбөр, үйлдвэрт нийлүүлэх	Төслийн талбай	2 удаа	-	ҮАЗ	ҮАЗ	Жилд 1-2	Ерөнхий гүйцэтгэгч	сайдын 2018 оны 11-р сарын 17 өдрийн А/443-р тушаалын хавсралт Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
4	Бусад хог хаягдлыг гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	удаа	ҮАЗ	12.00	ҮАЗ	Улирал бүр	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.4-р зүйл, 4-р бүлэг

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

5	Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх	Ерөнхий гүйцэтгэгч	удаа	ҮАЗ	2.00	ҮАЗ	Тухай бүрл хөтөлж, жил бүрийн 12 дугаар сарын 15-аас өмлнө тайлан мэдээг гарган хүргүүлэх	Ерөнхий гүйцэтгэгч	БОНХЯ-ны 2018 оны А/428 дугаар тушаал Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтөлж, тайлагнах журам
6	Газрын доорх усны эх үүсвэр, хөрс, агаарыг бохирдуулахгүй хүчитгэсэн доторлогоотой, давтан ашиглах шаардлага хангасан хийц бүхий нэвчилтгүй суурийн нүхтэй нийтийн бие засах газрыг байгуулах;	Төслийн талбай	Ширхэг	ҮАЗ	Шинээр жорлон барих бүх газарт	ҮАЗ	Үйл ажиллагаа хэлэх үед	Ерөнхий гүйцэтгэгч	Нүхэн жорлон , угаадасны нүх Техникийн шаардлага MNS 5924 : 2015

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

7		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай	удаа	1.00	2.00	ҮАЗ	Жилд 2 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.10 дугаар заалт
8	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, төслийн талбайд зориулалтын савыг байрлуулан, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбай	удаа	2.50	1.00	ҮАЗ	Эхний жил	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 5 дугаар бүлэг
9		Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах шилжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналтыг тавих,	СРМ	-	ҮАЗ	-	ҮАЗ	Сар бүр	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 28 дугаар зүйл

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

10	Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрд сургаж, дадлагажуулах	АХХ-тай харьцах ажилчид	Сургалт нэгж	1.00	1.00	ҮАЗ	Жилд 1 удаа	Ерөнхий гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 5 дугаар бүлэг
11	Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах	Төслийн талбай	кг	ҮАЗ	-	ҮАЗ		Ерөнхий гүйцэтгэгч	
Нийт						-			

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, сая/төг	Нийт зардал, сая/төг	Тайлбар	Хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт, арга, аргачлал
2	Агаарын чанар Орчны тоосжилт (PM2.5, PM10, TSP, CO, NO2, SO2)	Карьер 1-20	Улиралд 1	2	0.5	ҮАЗ	Багажны үнэ	Ерөнхий гүйцэтгэгч	MNS 4585: 2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
3	Хөрсний хими болон физик Хүнд металл	Карьер 1-13	Улиралд 1 удаа	2	0.3	ҮАЗ		Ерөнхий гүйцэтгэгч	MNS 2305:1994 Хөрс. дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 5850:2019
4	Усан орчин Ерөнхий хими физикийн шинжилгээ, Урвалын орчин (рН), Хүнд металлын шинжилгээ	Худаг 1-8 Гурван тэсийн 3 худаг	Улиралд 1 удаа	2	0.5	ҮАЗ		Ерөнхий гүйцэтгэгч	MNS 0900:2018 MNS6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS ISO5667-11:2000. Усны чанар-дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

5	Ургамлан нөмрөг	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд-12 цэг	Жилд 1 удаа	1	1.0	ҮАЗ		Ерөнхий гүйцэтгэгч	Батлагдсан аргазүй
6		Төслийн талбай болон түүний ойролцоох уст цэг, модлог бутлаг ургамал бүхий талбайд-5 цэгт	Жилд 1 удаа	1	1.0	ҮАЗ		Ерөнхий гүйцэтгэгч	
7	Амьтдын аймаг	Төслийн талбайд хамаарах газар нутгийн зэрлэг амьтдын нүүдлийн замналын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Жилд 1 удаа	1	1.0	Хөндлөнгийн хяналтын зардалд багтсан		Захиалгч	Хөндлөнгийн хяналтын мэргэжлийн байгууллагаар хийлгэх
		Зардал				-			
10	Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээ	Дотоод хяналтын цэгүүдэд	Жилд 1 удаа	1	12.6	12		Захиалгч	Холбогдох стандартын дагуу
Нийт						12.00			

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая/төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Хэрэгжүүлэгч	Тайлбар
1	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	40	Жилд 1 удаа	Удирдлага	Захиалагч, Ерөнхий гүйцэтгэгч	
2	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг ирэх жилийн БОМТ-ний ажилд тусгах	ҮАЗ	Жилд 1 удаа	БОМ	Захиалагч, Ерөнхий гүйцэтгэгч	
Нийт		40.0				

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах	Зохион байгуулах газар	
1	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 1 болон 3 дугаар баг, Өмнөговь аймгийн Гурван тэс сумын 1-5 дугаар багуудын ИНХ-д	БОМТ-ний хүрээнд гүйцэтгэсэн ажлын хураангуй	БОМТ-ний хүрээнд гүйцэтгэсэн ажлын хураангуй	Тухайн жилд	ҮАЗ	Төслийн менежер, Байгаль орчны мэргэжилтэн	Багийн төв	
2	Гурван тэс болон Шинэжинст сумын ЗДТГ-г	ҮАЗ	Жилд 1 удаа		ҮАЗ		Шинэжинст болон Гурван тэс сум	
3	Баянхонгор болон Өмнөговь аймгийн БОАЖГ-г	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	2 жилд 1 удаа		11 дүгээр сарын 1-ний дотор		ҮАЗ	Аймгийн БОАЖГ
4	БОУАӨЯам	ҮАЗ	тухайн жилийн тайлан		12 дугаар сарын 1-ний дотор		ҮАЗ	Улаанбаатар

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төсөл

14. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	20.0
2	Орчны тохижилт нөхөн сэргээлт	ҮАЗ
3	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	8.0
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардлаас
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	12.0
7	Удирдлага зохион байгуулалт	40.0
	Нийт зардал	80.0